



GREEN
CLIMATE
FUND




**“МОНГОЛ ОРНЫ ХӨДӨӨГИЙН ИРГЭДИЙН
УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН
ЗОХИЦОХ ЧАДАМЖ БОЛОН ЭРСДЭЛИЙН
МЕНЕЖМЕНТИЙГ БОЛОВСРОНГУЙ
БОЛГОХ НЬ” ТӨСӨЛ**

ТӨСЛИЙН ТОВЧООН

ЗОРИЛГО:

Байгалийн нөөцөөс хамааралтай хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамжийг дээшлүүлэх



Хэрэгжих хугацаа:

2021-2028 он



Санхүүжүүлэгч байгууллага:

Уур амьсгалын ногоон сан



Хэрэгжүүлэгч талууд:

БОАЖЯ, ХХААХҮЯ, НҮБХХ

Хэрэгжих газар:

Дорнод, Сүхбаатар, Завхан, Ховд аймгийн 68 сум



Оролцогч талууд:

Төслийн зорилтот аймаг, сумын Засаг даргын тамгын газар, бусад холбогдох төр, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагууд, байгалийн нөөцийн хамтын менежментийн байгууллагууд, малчид

Төсөл хэрэгжих үндэслэл:

Сүүлийн 70 жилд Монгол орны хэмжээнд агаарын температур 2.25°C-аар нэмэгдсэн нь Монгол орныг уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их өртөж буй улс орны тоонд оруулж байна. Агаарын температур нэмэгдэхийн зэрэгцээ хур тунадасны хэмжээ буурсан нь цөлжилт, хуурайшилтыг нэмэгдүүлж, бэлчээр, усны нөөцийг багасган, байгалийн бүс бүслүүр шилжихэд хүргэж байна.

Түүнээс гадна зуд турхан ган гачиг, их цас унах, шар усны үер буух болон хэт халж, хэт хүйтрэх зэргээс учрах гамшигт үзэгдлийн давтамж, эрчим нэмэгдэж байна. Жилийн дөрвөн улиралд байгалийн нөхцөлөөс шууд хамааралтай байдаг малчдын зүгээс уур амьсгалын нөлөөлөлд хэрхэн дасан зохицох, хариу үйлдэл, нөлөөлөх талаар зохих мэдлэг, мэдээлэлгүйгээр зохион байгуулагдаж ирсэн.

Мал маллагааны арга ажиллагаа, малын тоо толгой зохисгүй хэмжээнд байгаа нь улам бүр эмзэгшиж буй экосистем, экосистемийн үйлчилгээнд давхар нэрмээс болж байна.

ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН



Бүрэлдэхүүн хэсэг 1:

Үндэсний болон бүс нутгийн түвшинд газар, усны ашиглалтыг уур амьсгалын мэдээлэлд тулгуурлан төлөвлөж, хэрэглэдэг болох

Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон хөгжлийн урт хугацааны төлөвлөгөө болон дунд хугацааны төлөвлөлт хийх мэргэжлийн чадавхыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Төсөлд хамрагдсан аймаг, сумын хөгжлийн төлөвлөлтийг бэлчээрийн даац, уур амьсгалын өөрчлөлтийн мэдээлэлд үндэслэн боловсруулж, гол мөрний сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг шинэчлэх,

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр үүсэх эрсдэлийг даван туулах чадвартай мал аж ахуйн үйлдвэрлэлд газар, усны тогтвортой менежментийг хэрэгжүүлэх бодлого, зохицуулалтын шинэчлэлд шаардлагатай судалгаа, дүн шинжилгээг хийх



Бүрэлдэхүүн хэсэг 2:

Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон ус, хөрсний менежментийн арга ажиллагааг өргөн хүрээнд нэвтрүүлэн байгалийн нөөцийн менежментэд малчдын оролцоог нэмэгдүүлэх

Байгалийн нөөцийн хамтын менежментийн байгууллагыг чадавхжуулж, бэлчээр, усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хамтран хийх, гэрээгээр албажуулж хэрэгжилтийг сайжруулсан байна. Үүнд:

- Голын сав газрын дагуу татмын ойн нөхөн сэргээлтийг хийх
- Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй амьжиргааны тогтворгүй байдлыг багасгах зорилгоор хадлангийн болон нөөц бэлчээрийн газар байгуулах, онцгой байдлын үед хэрэглэх хадлан, тэжээлийн агуулах барих
- Булаг, шандыг хамгаалах, цас, бороо, гадаргын ус хуримтлуулах хөв барих, услалтын системийг засварлах, шинээр худаг гаргах, засварлах усны хүртээмж, бэлчээр усжуулалтыг сайжруулах, ашиглагдахгүй байгаа бэлчээрийг эргэлтэнд оруулах зэрэг багтана.



Бүрэлдэхүүн хэсэг 3:

Гарал үүсэл нь тогтвортой, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй малын бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх малчдын чадавхыг нэмэгдүүлж, бэхжүүлэх

- Гарал үүсэл нь тогтвортой, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй малын чанартай түүхий эдийн бэлтгэл, нэмүү өртгийн сүлжээ бий болгож, газар нутгийн экосистемийн даацад сүргийн хэмжээг тохируулан барих хүчин чармайлтыг дэмжсэн төр, хувийн хэвшил, нөхөрлөлийн түншлэлийг хөгжүүлэх
- Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах чадвартай бэлчээр, усны төлөвлөлт, тогтвортой ашиглалтыг дэмжсэн, малчин өрхийн сайн сайхан байдалд хувь нэмэр оруулах бизнесийн чиг баримжаатай байгууллага байгуулах, сургалт зохион байгуулах
- Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон малын гарал үүсэл нь тогтвортой бүтээгдэхүүнийг бэлтгэх, мөшгих боломжийг сайжруулах
- Дотоодын болон олон улсын зах зээлд гарал үүсэл нь тогтвортой, малын чанартай бүтээгдэхүүний ханган нийлүүлэлт хийх таатай нөхцөл бүрдүүлэх, мэдлэгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх



ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН

Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг иргэд, орон нутаг, бүс нутгийн өртөмтгий байдал багасч, даван туулах чадвар нэмэгдсэн байна.

- Хамрах хүрээ: Дорнод, Сүхбаатар, Завхан, Ховд аймгийн 68 сум

- Шууд үр шим хүртэгчид

130,000 хүн

- Шууд бусаар үр шим хүртэгчид

800,000 хүн

- Аймаг, сумын хөгжлийн төлөвлөлтийг бэлчээрийн даац, уур амьсгалын өөрчлөлтийн мэдээлэлд үндэслэн гаргах, гол мөрний сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг шинэчлэхэд дэмжлэг үзүүлсэн байна.
- Малчид уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй мал сүрэгтэй болох, гарал үүсэл нь тогтвортой чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд харьцангуй өндөр үнэтэй нийлүүлэх боломжийг бүрдүүлнэ.


Экосистемийн даац, үйлчилгээ сайжирсан байна.

**14 сав газар,
36.44 сая га**



Уур амьсгалын мэдээлэлд түшиглэсэн төлөвлөлтийг дэмжсэн институцийн болон зохицуулалтын тогтолцоо бэхэжсэн байна.

- Уур амьсгалын мэдээлэл боловсруулж, ашиглан шийдвэр гаргах байдал сайжирсан байна.
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж сайжирч, өртөх эрсдэл буурсан байна.



Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх



Хөдөөгийн иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн арга хэмжээ хэрэгжүүлэх



Эх дэлхийгээ урт хугацаанд хамгаалах



Ус намгархаг газрыг нөхөн сэргээх



Уур амьсгалд зохицсон мал аж ахуйн үйлдвэрлэл



Газрын тогтвортой менежмент



Усны нөөцийн нэгдсэн менежмент



Ландшафтын нөхөн сэргээлт



Бороо, цасны усыг хуримтлуулах



Малын хадлан, тэжээл хадгалалт



Газар нутгийг хамгаалалтад авах

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн хаяг:

Монгол улс, 15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Анкарагийн гудамж 23, Тод товер 1002 тоот